

МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ ХИЧЭЭЛИЙН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙН СУДАЛГАА

Н.Уянга¹, Н. Болормаа¹, Г.Цэндмаа¹, Ц.Болормаа¹
¹АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь АУС
uyanga.n@mnums.edu.mn

Хураангуй

Мэдээллийн технологийн салбар асар хурдтай хөгжиж байгаа эрин үед анагаахын мэргэжил эзэмшиж буй суралцагсдын хувьд хэрэглээний програм хангамжийг бүрэн эзэмших, интернетийн орчинд ажиллаж сурах, мэдээллийг боловсруулах, ажил, амьдралдаа өргөн ашиглаж сурах зайлшгүй шаардлага тавигдаж байгаа юм.

Сургалтын хөтөлбөрт тусгагдсанаар анагаахын дипломын болон бакалаврын боловсрол эзэмшиж байгаа оюутнуудын мэдээллийн технологи хичээлээр судалсан хэрэглээний програм хангамжийг эзэмшсэн байдал, суралцагсдын сэтгэл ханамжийн байдлыг тодорхойлох, энэ нь сургалтын үр дүнд хэрхэн нөлөө үзүүлж буйг тодорхойлох шаардлагатай байна.

Мөн интернэтийн орчинд мэдээллийн технологи хичээлийг суралцагсад цахимаар бэлтгэж, орон зай цаг хугацаанаас үл хамааран суралцах боломжийг олгох, түүний давуу ба сул талыг тодорхойлох шаардлага тулгарч байна.

Цахим сургалт нь орчин үеийн сургалтын арга хэлбэрүүдийн нэг болж хөгжиж байгаа бөгөөд энэ аргыг мэдээллийн технологийн хичээлд ашигласнаар суралцагсад бие даах чадварт хэрхэн суралцаж байгааг тодорхойлох нь чухал.

Мэдээллийн технологи хичээлийг дадлага, семинарын хэлбэрээр ордог бөгөөд үнэлгээ хэр бодитойг тодорхойлох хийгээд үнэлгээндээ анализ хийснээр цаашид юуг анхаарах талаар судлах шаардлагатай юм.

Түлхүүр үгс: Суралцагсад, сэтгэл ханамж, хандлага, цахим сургалт, үнэлгээ

Үндэслэл:

Суралцагсад мэдээлэл, өгөгдөл, мэдээллийн үнэцэнэтэй танилцан эрүүл мэндийн салбарт өргөн тохиолдох мэдээллийн урсгалыг судлах, дүрслэн үзүүлэх, статистикийн анхан шатны тооцоо хийх, мэдээллийн сан үүсгэж боловсруулах, сан дотроо хялбар хайлт хийх, тайлан гаргаж сурах, ахисан түвшинд онол, практикийн тооцоонд хэрэглэн, үнэлж сурах нийгмийн хэрэгцээ тулгарч байгаа юм.

Энэ хэрэгцээг хангах үүднээс мэдээллийн технологи хичээлийг дипломын болон бакалаврын сургалтад нийт 64 багц цагийн агууламжаар судалдаг бөгөөд энэ хичээлээр статистикийн анхан шатны тооцоо хийх MS Excel, өгөгдлийн санг зохион байгуулах, боловсруулах MS Access, илтгэл, танилцуулга, үзүүлэнгийн програм

хангамж MS PowerPoint, нээлттэй програм хангамжийн талаарх цогц чадамжийг эзэмшдэг болно. Интернетийн сүлжээ, компьютерийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, анги танхим, зурагт, хичээлийн хэрэглэгдэхүүн, багшийн ур чадвар, хичээлийн хөтөлбөр, төлөвлөгөө, ном сурах бичиг, гарын авлага, үзүүлэн, таниулах материал, хичээлийн зохион байгуулалт нь сургалтын үр дүн, суралцагсдын хэрэгцээ шаардлагад шууд нөлөөлж байдаг.

Сургалтын явцад оюутнууд хэрхэн идэвхи чармайлт гаргасан, хэр сонирхсон, хичээлийг ямар хэлбэрээр явуулбал илүү үр дүнтэй байх, шалгалтыг ямар хэлбэрээр авах зэрэг нь энэ хичээлийн үр дүнд шууд нөлөөлнө гэж үзэж байна.

Энэ хичээлийг судалснаар оюутнууд мэдлэг, чадвар, хандлагын хувьд хэрхэн ахисан болох, суралцах сургалтын орчин хэрхэн хангагдаж байсан, цахим сургалтаар суралцагсад хэрхэн үр дүнтэй суралцсан, оюутнуудыг үнэлэх хэлбэрт үнэлэлт өгөх талаар судлах зайлшгүй шаардлага тулгарч байгаа юм.

Зорилго: Мэдээллийн технологи хичээлээр суралцагсдын сэтгэл ханамжийн түвшин хэрхэн хангагдсан, суралцагсдын хандлага, үнэлэх арга, цахим сургалтын үр дүнг тодорхойлох

Судалгааны зорилт:

- Мэдээллийн технологи хичээлийг судалснаар суралцагсдын мэдлэг чадварын түвшний ахиц дэвшлийг тодорхойлох
- Мэдээллийн технологи хичээлд суралцагсдын хандлагыг тодорхойлох
- Мэдээллийн технологи хичээлийн цахим сургалтын үр дүнг тодорхойлох
- Мэдээллийн технологи хичээлээр суралцагсдын үнэлгээнд тулгуурласан асуудлуудыг тодорхойлох

Судалгааны материал, арга зүй:

Судалгааг АШУҮИС-ийн Дархан АУС-ийн мэдээллийн технологи хичээлийг үзэж, судалсан 74 оюутныг хамруулан 35 асуумжаар авч, судалгааны үр дүнг MS Excel, SPSS програмаар боловсруулалт хийв.

Судалгааны үр дүн

Судалгаанд тус сургуульд суралцаж байгаа, мэдээллийн технологи хичээлийг үзэж судалсан I курсын оюутнууд хамрагдсан. Хичээлийн хөтөлбөрт тусгагдсанаар дипломын болон бакалаврын сургалттай ангиудад MS Excel, MS Access, MS PowerPoint хэрэглээний програмуудыг судалдаг. Судалгаанд хамрагдсан оюутнуудын тус сургуульд элсэн суралцахаас өмнө хэрэглээний програмуудыг хэрхэн эзэмшсэн талаарх асуумжид 19% нь Windows, 32.5% нь MS Word, 29.7% нь MS Excel, 44.6% нь MS Powerpoint, 44.6% нь MS Access, 60.8% нь Internet, 5.4% нь SPSS, 2.7% нь бусад програмуудыг сайн мэддэг байсан гэж тус тус хариулсан байна.

Таны суралцаж байгаа мэргэжилд мэдээллийн технологи хичээл хэр зэрэг хэрэгцээ шаардлагатай гэж үзэж байна вэ? гэсэн асуумжид маш их шаардлагатай 35%, шаардлагатай 54%, дунд зэрэг шаардлагатай гэж 68% гэж хариулсан бол шаардлагагүй гэсэн хариулт байхгүй байсан байна. Мэдээллийн Танд мэдээллийн технологи хичээлийг судалснаар өөр бусад хичээлүүдийн бие даалтыг хийх болон судлахад хэр зэрэг ач холбогдолтой гэж үзэж байна вэ? гэсэн асуумжинд 51.4% нь ач холбогдолтой, 51.4% нь маш их ач холбогдолтой гэж хариулжээ.

Хүснэгт I. Та мэдээллийн технологийн хичээлийн талаар ямар санал хүсэлт байна вэ? гэсэн асуултын үр дүн

№	Үзүүлэлт	шаардлагатай	шаардлагагүй	болж байна
1.	Дадлагын хичээлийн цагийг нэмэгдүүлэх	34(45.9%)	12(16.2%)	20(27%)
2.	Лекцийн хичээлийг оруулах	26(35.1%)	29(39.2%)	12(16.2%)
3.	Ном сурах бичиг гарын авлагаар хангах	50(67.6%)	5(6.8%)	13(17.6%)
4.	Компьютерийн кабинетуудыг нэмэгдүүлэх	49(66.2%)	7(9.5%)	12(16.2%)

Мэдээллийн технологи хичээлийг судлахаас өмнө ба судалсны дараахь суралцсан чанар дараахь өсөлттэй байна. Үүнд : Windows програмыг 50% нь, MS Word програмыг 64,7% нь, MS Excel програмыг 75,7% нь, MS PowerPoint програмыг 67,5% нь, Internet програмыг 64,9% нь, MS Access програмыг 51,3% нь, SPSS програмыг 25,7% нь онц сайн ба хангалттай сайн суралцсан гэж хариулсан нь сургалтын үр дүн дээшилж буйг харуулж байна. Мэдээллийн технологи хичээл нь бусад хичээлд суралцах явцад хэр үр өгөөжөө өгсөн гэж үзэж байна вэ? гэсэн асуултанд 20% нь маш их, 48% нь их, 32% нь дунд зэрэг үр өгөөжөө өгсөн гэж үзсэн бөгөөд бага, маш бага гэсэн хариулт байхгүй байлаа.

Та мэдээллийн технологи хичээлд хэр сонирхолтой байсан бэ? гэсэн асуултанд 48% нь маш их, 45,3% сонирхсон, 6,7% нь дунд зэрэг сонирхсон гэж хариулжээ. Та мэдээллийн

технологич хичээлийг суралцах явцад хэр зэрэг идэвхи зүтгэл гаргасан бэ? гэсэн асуултанд 21,3% нь маш их хичээсэн, 78,7% нь хичээсэн гэж хариулсан байна. Мэдээллийн технологи хичээлийн бие даалтын ажлыг ямар хэлбэрээр тооцуулах нь зөв гэж үзэж байна вэ гэсэн асуултанд 65,3% нь хичээлтэй холбоотой сэдвээр даалгавар гүйцэтгэх, 28% нь чөлөөт сэдэв сонгож, мэдээлэл цуглуулж, амаар асуугдах гэсэн хариултыг сонгосон байна.

Цахим сургалтаар мэдээллийн технологи хичээлийн сэдвүүдийг програм ашиглан бэлтгэж, суралцагсад хүргэхэд даалгаврын гүйцэтгэл 96% байна. Цахим сургалтын давуу ба сул тал нь юу байна вэ? гэсэн асуултанд бие даан суралцах арга барилд суралцаж байна 15%, хичээл ойлгомжтой заагдаж байгаа гэж хариулсан 35,8% байсан бол багшаас болон найз нөхдөөсөө асуух зүйлээ шууд асуух боломжоор сул гэж хариулсан 8,4%, компьютер байхгүй, интернетийн сүлжээ хөдөө зарим газруудад муу байгаа гэж хариулсан 12,4%, цахим хичээл болж байна гэж хариулсан 43,4% нь байв.

Суралцагсдаас гардан гүйцэтгэлээр болон онолын тестээр үнэлэхэд гардан гүйцэтгэл 85,6%, онолын тестийн үнэлгээний зөв хариултын гүйцэтгэл 55,1% байлаа.

Дүгнэлт:

Мэдээллийн технологи хичээл нь бусад хичээлүүдийг биедаан суралцах цахим орчин болох төдийгүй цаашид энэ хичээлийг бүх мэргэжлийн ангиудад заавал судлах зайлшгүй шаардлагатай хичээлүүдийн нэг юм. Энэ хичээлийг судалснаар оюутнуудын хэрэглээний програмуудыг эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагын түвшин MS Excel програм дээр 46%-аар, MS PowerPoint програм дээр 22,9%-аар, MS Access програм дээр 33,7%-аар тус тус өссөн байна.

Мэдээллийн технологи хичээлд суралцаж байгаа оюутнууд уг хичээлд сонирхолтой, өөрсдийнхөө зүгээс хичээл зүтгэлтэй, нэлээд чармайдаг бөгөөд хичээлтэй холбоотой сэдвээр бие даалтыг гүйцэтгэх, багаар ажиллах, сургалтын хангагдсан орчинд сургалт үр дүнтэй явагдах бөгөөд сургалтын дадлагын хичээлийн шалгалтыг онолын тестээр шалгах нь оновчтой арга биш байна.

Мэдээллийн технологи хичээлийн хувьд цахим сургалт нь зайлшгүй интернетийн сүлжээний хүчин чадал, техник технологийн асуудлыг шийдвэрлэж суралцах шаардлагатай байгаа нь суралцагсдын хувьд бэрхшээл учруулах учир дутагдалтай байна.

Мэдээллийн технологи хичээлийг судалж буй оюутнууд 85,6% гүйцэтгэлтэй байгаа нь дадал чадварыг сайн эзэмшиж байгааг харуулж байна. Гэвч онолын шалгалтын гүйцэтгэл 55,1% байгаа нь суралцагсад онолын мэдээллийн эх сурвалжуудаар (ном, сурах бичиг, гарын авлага гэх мэт) хангалтгүй байгааг харуулж байна.

INFORMATION TECHNOLOGY COURSE QUALITY AND ACCESSIBILITY STUDY

N.Uyanga¹, N.Bolormaa¹, G.Tsendmaa¹, Ts.Bolormaa¹

¹Darkhan-Uul Medical school of MNUMS
uyanga.n@mnums.edu.mn

Abstract

Rapidly growing IT period the students, who are studying in the field of medical science need to access using software, learning to work on Internet, developing data, producing results, and implementing in their work and life. According to the curriculum, it is necessary to analyze, evaluate, and determine the effectiveness of the learning outcomes of the software.

We analyze to define the attitude toward students' class and to define satisfaction on ability to learn computer programs of the students with diploma and bachelor degree. Based on this research we found out the big needs to determine the influence of studying to their success.

There are also big current problems with preparing the students for e-learning courses in Internet medium to allow them to study regardless of distance and time to identify its advantages and disadvantages.

E-learning is developing as one of the most important learning method, which helps to reach the result to determine what outcomes can be achieved by the students and to learn the ability to study by their own, based on attending computer classes.

Information technology takes the form of workshops and workshops, and it is important to determine what the assessment is realistic and analyze the assessment to see what to look for next.

Ном зүй:

1. Ганчимэг Ө. (2009) SPSS програм суралцах гарын авлага УБ
2. Ажнай Л., Ахыт Т. (2012) Компьютерийн практикум - I
3. Цэдэвсүрэн, Д. (2010) МХХТ-ийг нэвтрүүлж буй өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага. УБ.
4. Байгалтөгс, С. (2012) Монголын е – Сургалтын чанарын баталгаажуулалтын бодлогын асуудалд. .ШУТИС. ЭШБ эмхэтгэл. №4/127.
5. Оюунгэрэл, Д. (2012) Сургалт удирдлагын системийг цахим хэрэгслүүдтэй холбож ажиллах хэрэглээний судалгаа. ЭШ өгүүлэл.
6. Мэдээллийн технологи хичээлийн хөтөлбөр